


**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

|  |   |
|--|---|
| Огноо (он, сар, өдөр):   | 2024 оны 4-р сарын 29   |
| Үнэт цаас гаргагчийн нэр:  | АПУ ХК  |
| Үнэт цаасны нэр, үсгэн код:  | APU, 90   |
| Салбарын ангилал:  | Шингэн хүнс   |
| Тайланд хамрагдсан компаниуд   | АПУ ХК  |
| Тайлангийн хамрах хугацаа:   | 2023.01.01-2023.12.31   |
| Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас: | Мэндбаярын ЗОЛЖАРГАЛ<br>Тогтвортой хөгжил хариуцсан менежер<br>zoljargal.m@apu.mn, 99280460 |
| Тайланг баталгаажуулсан гүйцэтгэх удирдлагын мэдээлэл (нэр, албан тушаал):       | Цэвээнжавын ЭРДЭНЭБИЛЭГ<br>Гүйцэтгэх захирал  |
| Гүйцэтгэх удирдлага эсвэл ТУЗ-ийн даргын гарын үсэг:                             |            |

| Бүлэг                  | Шалгуур үзүүлэлт                          | Үзүүлэлт (тайлант он)  | Хэмжих нэгж | Нэмэлт мэдээлэл | Тайлбар  |
|------------------------|---|--|-------------|-----------------|--|
| 1. Тогтвортой хөгжлийн | 1.1 Бодлого, стратеги, зорилтууд          | Тогтвортой хөгжлийн бодлого, стратеги болон зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх   | Үгүй        |                 | Тогтвортой хөгжлийн стратегийг тодорхойлсон ба 2024 оны 2-р хагаст багтаан ТУЗ-өөр батлуулах төлөвлөгөөтэй, одоо үйл ажиллагааны төлөвлөгөөний ажлыг Ажлын хэсэг томилогдон бэлтгэж байна.   |
|                        | 1.2 Бүтэц удирдлага                       | Тогтвортой хөгжлийн асуудлыг хариуцдаг хороо(д) байдаг уу?   | Үгүй        |                 | Стратегийг ТУЗ баталсны дараа томилогдоно.   |
|                        |   | ТУЗ-ийн түвшинд тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан гишүүн байдаг эсэх   | Үгүй        |                 | Стратегийг ТУЗ баталсны дараа томилогдоно.   |
|                        |   | Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх  | Тийм        |                 | Гүйцэтгэх захирал  |
|                        |   | Тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан газар нэгж/хариуцсан ажилтан/ууд (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх  | Тийм        |                 | Тогтвортой хөгжил хариуцсан менежер, Тогтвортой хөгжил хариуцсан ажилтан   |
|                        | 1.3 Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ | Танай компани тогтвортой байдлын нөлөөллийн (materiality assessment) үнэлгээ хийдэг үү? Үүнд танай компанийн (1) эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах, (2) уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээ зэрэг багтана. | Тийм        |                 | Эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах зорилгоор CO2 бууруулах уурын зуухны төсөл, Саарал усны хаягдлыг дахин ашиглах төсөл, Монгол бяслаг Шигүдэри урлах үйлдвэрийн хүлэмжийн хийг бууруулах шийдлүүд, Хог хаягдлын 3R стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Мөн нийгэм чиглэлд гайхамшигт жолооч гэж уусан бол жолоо барьдаггүй жолоочийг хэлнэ уриатай "Гайхамшигт жолооч" нөлөөллийн аяныг зохион байгуулсан |

|                                |  |  |  |                      |  |  |
|--------------------------------|--|--|--|----------------------|--|--|
| удирдлагын систем (ТХУС)       | 1.4 Тайлагнал  | Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайлангийн нэг хэсэг эсвэл тусдаа тайлан байдлаар)-гаа жилд нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу? | Тийм   |                      | <a href="https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2023/04/SustainabilityReport_2022_FINAL.pdf">https://www.apu.mn/wp/wp-content/uploads/2023/04/SustainabilityReport_2022_FINAL.pdf</a>  |  |
|                                | 1.5 Мэдээллийн баталгаажуулалт   | Тогтвортой байдал буюу байгаль орчин, нийгэм, засаглалын мэдээллийг хараат бус гуравдагч этгээдээр баталгаажуулдаг уу?                                   | Үгүй   |                      |  |  |
|                                | 1.6 Тогтвортой хөгжлийн зорилтууд (ТХЗ)-ыг хэрэгжүүлэх чиглэлээрх хамтын ажиллагаа | НҮБ -ын ТХЗ-уудын хүрээнд хэрэгжүүлж буй хамтын ажиллагаа  | Тийм   |                      | Спорт, ногоон санхүү, Монгол Сарлаг гэр үйлдвэрлэлийн төсөл, Гайхамшигт жолооч, үйлдвэрийн хог хаягдал ус боловсруулах байгууламж зэрэг ажлуудыг дараах "НҮБ Тогтвортой Хөгжлийн Зорилтууд 2030" хүрээнд хийгдэж байгаа.<br>#3: Эрүүл мэндийг дэмжих<br>#6: Баталгаат үндны ус, ариун цэврийн байгууламжаар хангах<br>#8: Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих<br>#9 Инновац болон дэд бүтцийг хөгжүүлэх<br>#10 Тэгш бус байдлыг бууруулах<br>#12: Хариуцлагатай хэрэглээг дэмжих<br>#13: Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах |  |
|                                | 1.7 Гишүүнчлэл   | Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аливаа сүлжээ, холбоонд нэгдсэн үү?   | Тийм   |                      | Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо   |  |
| 2. Эрчим хүч                   | 2.1 Цахилгаан  | Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)   | Цахилгааны нийт хэрэглээ - 9449546 , Хэмнэлтийн хэмжээ - 66528 | кВтц                 | Цахилгааны дэд тоолууржуулалт, 40 барын хийн компрессороос хаягдаж байгаа халуун агаарыг цахилгаан халаагуурын оронд ашигласан, үйлдвэр оффис гэрэлтүүлгийг Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй LED гэрэлтүүлэгчээр сольсон  |  |
|                                | 2.2 Дулаан   | Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)  | Зарцуулалт: 51877.93; Хэмнэлт: 3631.46                         | ВТУ & % Гкал         | 2024 онд хаягдал кондинсацыг дахин ашиглаж дулааны зарцуулалтыг 20% бууруулахаар ажиллаж байна   |  |
|                                | 2.3 Түлш   | Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)  | 10000  | Литр/кг & % (ГЖоулс) | СББТ компанийн 2023 оны сарын нийт автомашины түлшний зарцуулалт 39.5 сая ₮ байгаагаас Импортын түгээлтийн 2 цахилгаан автомашин ашигласнаар 4.7% хэмнэлт буюу сард дунджаар 1.8 сая хэмнэсэн  |  |
|                                | 2.3 Үл сэргээгдэх эрчим хүч  | СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь   | 100  | %                    | Төвийн цахилгаан эрчим хүч /нүүрс/   |  |
|                                | 2.4 Сэргээгдэх эрчим хүч (СЭХ)   | СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь   | 0  | %                    |  |  |
| 3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт | Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн      |  |  | CO2/тонн             | 2024 онд тооцуулна.  |  |



|                           |   |  |               |          |  |                                      |
|---------------------------|---|--|---------------|----------|--|--------------------------------------|
| 3. Хүлэмжийн хийн ялгарал | 3.2 Бууруулсан хүлэмжийн хий  | Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)  |               | CO2/тонн | 1 литр түлш шатаахад 3кг CO2 ялгарна. ТТДЛбаны нийт 115 автомашин 2023 онд 1.333.069 л түлш зарцуулсан гэж тооцвол 3.999.207кг CO2 хүлэмжийн хий ялгаруулсан байна. СББТ компанийн 45 автомашиныг 2 цахилгаан автомашинтай харьцуулахад хүлэмжийн хийн ялгарал сарын дунджаар 4.8% буурсан харагдаж байна  | 2024 онд группийн хэмжээнд тооцуулна |
|                           | 3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/                              | Танай компани карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлдэг үү? (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гадны төслийг дэмжих гэх мэт)   | Тийм          |          | Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол, Нийслэлийн засаг даргын 2021 оны А/908 дугаар захирамжийн дагуу "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хэрэгжилтийг хангуулж ажиллахаар нийслэлийн нутаг дэвсгэрт нэгдсэн зохион байгуулалтаар шилмүүст мод тарих ажилд АПУ ХК компани нь 1500 ширхэг шинэс мод тарихаар "НҮРИ" ХХК хамтран ажиллахаар гэрээг байгуулж ажиллалаа |                                      |
| 4. Уур амьсгалын өөрчлөлт | 4.1 Уур амьсгалын бодлого, журам                                      | Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой уу?  | Үгүй          |          | Компанийн чанар, байгаль орчин, хүнсний аюулгүй байдлын нэгдсэн бодлоготой ба хог хаягдлыг багасгах, хүрээлэн буй орчны бохирдлыг бууруулах, байгальд зэлтэй буюу эрчим хүч болон усны хэмнэлттэй технологийг нэвтрүүлснээр байгаль орчинд үзүүлэх нөлөөллөө багасгах зорилготой   |                                      |
|                           | 4.2 Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ                         | Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү?(сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)   | Үгүй          |          |  |                                      |
|                           | 4.3 Эдийн засгийн хохирол   | Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ  | Тийм          |          | Группийн хэмжээнд нэгтгэж, хохирлын үнэлгээгээр тооцолол хараахан хийгээгүй  |                                      |
|                           | 4.4 Уур амьсгалын хөрөнгө оруулалт                                    | Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн  | 1,595,914,488 | Төгрөг   | Үйлдвэрийн хог хаягдал ус боловсруулах байгууламж барих төслийн судалгаа, дэд бүтцийн шугмын угсралт   |                                      |
|                           | 4.5 Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох | Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон уу? | Тийм          |          | Дунд хугацааны тогтвортой хөгжлийн стратегийн тэргүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон. Үүний дагуу хэрэгжүүлэх арга хэмжээнүүд 2024 онд тодорхой болно   |                                      |
|                           | 5.1 Усны хэрэглээ   | Ашигласан усны нийт хэмжээ   | 370,257       | м3/Л     | Нийт ашигласан усны хэмжээ   |                                      |
|                           | 5.2 Хэмнэсэн ус   | Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ   | 15,056        | м3/Л     | Дахин ашигласан усны хэмжээ: 15056 мкуб  |                                      |

|                              |  |  |            |                   |  |                                |
|------------------------------|--|--|------------|-------------------|--|--------------------------------|
| 5. Ус                        | 5.3 Бохир ус цэвэрлэх  | Цэвэрлэсэн нийт бохир усын хэмжээ  |            | м3/Л              | Одоогоор АПУ ХК нь хаягдал усаа цэвэрлэдэггүй, аль болох үйлдвэрийн хэмжээнд усны хэрэглээг бууруулах, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх, хаягдал усны хэмжээ болон үзүүлэлтийг бага байлгах тал дээр ажиллаж байна. Цаашид манай компанийн хаягдал ус цэвэрлэх байгууламжийн төсөл хэрэгжиж ашиглалтанд орсноор 100% өөрсдийн гаргасан үйлдвэрийн хаягдал усаа цэвэрлэж дахин ашиглах, стандартад нийцсэн хаягдал усыг төв ариутгах татуургад нийлүүлж ажиллана |                                |
| 6. Хатуу хог хаягдал         | 6.1 Хог хаягдал  | Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ   | 15,000     | тонн              | АПУ ХК-аас нийт 15 мянган тн хог хаягдал гарсан бөгөөд түүнээс 66% нь Landfill free буюу хог хаягдлын цэгт хаягдаагүй  |                                |
|                              | 6.2 Дахин боловсруулсан хатуу хог хаягдал                        | Хог хаягдлыг дахин боловсруулсан %   | 66         | %                 | Үйлдвэрээс гарах хаягдал дахин боловсруулах боломж бүхий хог хаягдлын хүрээнд 64 хувь 9700 тн пивоны хаягдал шаарыг Баялаг Фийд ХХК болон Улаанбаатар хот орчмын аж ахуй эрхлэгч малчин өрхөд нийлүүлсэн бол 299 тн буюу 2% бүхий модон подон, цаасан хайрцаг, лаз, пластик хаягдал, сахарын шуудай зэрэг дахин боловсруулах хаягдлуудыг Эко Орчин ХХК, Мультипак ХХК-уудад нийлүүлжээ   |                                |
|                              | 6.3 Хортой хог хаягдал   | Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)   | 7.3        | тонн              | Аюултай хог хаягдлыг устгах арга хэмжээг "Түмэг эгшиг" ХХК-тай гэрээ байгуулж ажиллав. Үйлдвэрээс химийн бодис агуулж байсан хуванцар сав, ашигласан техникийн хаягдал тос, шүлтийн шуудай зэрэг 7.3 тн хаягдлыг шууд устгалд оруулсан   |                                |
| 7. Биологийн олон янз байдал | 7.1 Ногоон байгууламж, төлөвлөлт                                 | Тогтвортойгоор ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн нийт талбай  | 214,328.40 | м2                |  |                                |
|                              | 7.2 Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах                            | Хамгаалсан төрөл зүйлийн тоо   |            | Төрөл зүйлийн тоо |  |                                |
|                              | 7.3 Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа | Танай компани биологийн төрөл зүйлд мэдрэмтгий бүс нутаг эсвэл ойролцоо газар үйл ажиллагаа явуулдаг эсэх талаар үнэлгээ, шинжилгээ хийдэг үү? | Үгүй       |                   |  |                                |
| 8. Хүний нөөц                | 8.1 Хүний нөөцийн тогтвортой байдал                              | Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)         | 21%        | %                 |  |                                |
|                              | 8.2 Шинээр бий болгосон ажлын байр                               | Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо   | 178        | Тоо               |  |                                |
|                              | 8.3 Сургалт  | Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг  | 5.53       | цаг               |  |                                |
|                              | 9.1 ХАБЭА-н бодлого  | ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэгсэн)?  | Тийм       |                   | Дотоодын бүх ажилчдад зориулан SharePoint-дээр байршсан байдаг   | ХАБЭА-н бодлого болон журамтай |



|   |   |  |                             |         |  |  |
|---|---|--|-----------------------------|---------|--|--|
| 9. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА) | 9.2 Осол аваар  | Үйл ажиллагааны явцад гарсан осол аваарын тоо, жилээр  | 0.1                         | хүн     | 2023 онд 200,000 хүн цаг тутамд ноогдох ослын давтамж 0.1 гэсэн үзүүлэлттэй байгаа нь Ази номхон далайн бүсдээ дунджаас доогуур буюу сайн үзүүлэлтэд орж байна.2023 онд аюул, ослыг бууруулах зорилгоор "Аюулгүй ажиллагааны манлайлагч" компани ажил, ХАБЭА-н Амь насаа хамгаалах 12 амлалт хэрэгжүүлэх, аюул ослыг мэдээлэх ТРМ гар утасны application-ийг нэвтрүүлэх зэрэг ажлууд хийгдсэн  |  |
|   | 9.3 ХАБЭА-н сургалт   | Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг  | 16.5                        | цаг     | Үйлдвэрлэл, үйл ажиллагааны ажилтанд жилд ноогдох дундаж сургалтын цаг 16.5 цаг байна  |  |
|   | 9.4 Эрүүл мэндийн хөтөлбөр                                      | Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр             | 9,878                       | хүн     | Эрүүл мэндийн зөвлөгөө, зөвлөмж 9,438<br>Эмийн: 10,822 /булчин, судас, дусал, арьсан доорх тариа/<br>Эмийн бус: 1,320 /бариа, бумба, шарлага, физик эмчилгээ/ Шинэ ажилтны эрүүл мэндийн шаардлагатай үзлэгийн төлбөрийг төлж, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн төвтэй хамтарч ажилладаг. АПУ Дэйри ХХК, М Би Си Азия Пасифик ХХК, АПУ Трейдинг ХХК зэрэг байршлууд дээр 7 хоногийн 5 дахь өдөр бүр байрлан ажиллаж нийт 31 удаа 440 ажилтанд зөвлөгөө өгсөн |  |
| 10. Эрх тэгш байдал                               | 10.1 Жендэрийн бодлого, журам                                   | Жендэрийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?                     | Тийм                        |         | Хөдөлмөрийн дотоод журам - Sharepoint (Бизнесийн ёс зүйн дүрэм, хөдөлмөрийн дотоод журмын 16 дахь заалт)   |  |
|   | 10.2 Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам         | Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?        | Тийм                        |         | Хөдөлмөрийн дотоод журам - Sharepoint (Бизнесийн ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмын 17 дахь заалт)   |  |
|   | 10.3 Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам               | Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)? | Тийм                        |         | Хөдөлмөрийн дотоод журам - Sharepoint (Бизнесийн ёс зүйн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журмын 18 дахь заалт)   |  |
|   | 10.4 Ажилтнуудын хүйсийн харьцаа                                | Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь  | Эрэгтэй 62%<br>Эмэгтэй 38%  | %       | HR BI report   |  |
|   | 10.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа                 | Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа                                      | Эрэгтэй 85%<br>Эмэгтэй 15%  | %       | Green ERP report   |  |
|   | 10.6 Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа                       | Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа                                  | Эрэгтэй 58%<br>Эмэгтэй 42%  | %       | Green ERP report   |  |
|   | 10.7 Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа | Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа                                | Эрэгтэй 66 %<br>Эмэгтэй 34% | %       | Green ERP report   |  |
|   | 10.8 Жендэрт суурилсан цалингийн зөрүү                          | Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа  | (-2.7%)                     | харьцаа | Эрэгтэй ажилтнуудын цалинг эмэгтэй ажилтнуудынхтай нийтэд нь харьцуулбал 2.7-аар бага, энэ нь ажлын зэргээс хамаарч буй юм   |  |

|  |   |  |      |   |   |  |
|--|---|--|------|---|---|--|
| 11. Хүртээмжтэй байдал                   | 11.1 Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд                                   | Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь   | 1.8  | % | HR BI report (Нийт ажилтнуудын эзлэх хувь 1.8%<br>Нийт 15 хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд ажилладаг)   |  |
|  | 11.2 Оффисын хүртээмж   | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн байгууламжийн хувь   | 10   | % |   |  |
| 12. Нийгмийн хариуцлага ба ил тод байдал | 12.1 Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт | Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь                      |      | % | Группийн хэмжээнд нэгтгэх, нийт орлогод эзлэх хувийг тооцоолох хараахан боломжгүй байна. 2024 онд нэгтгэж тооцох суурийг тавина.  |  |
|  | 12.2 Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам    | Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)                            | Үгүй |   |   |  |
|  | 12.3 Олон нийтэд ил тод мэдээлэх                                      | Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу? | Тийм |   | Бид компанийнхаа www.ari.mn веб сайтаар дамжуулж аливаа мэдээ, мэдээллийг түгээдэг. Манай компанийн бүтээгдэхүүн, үйл ажиллагаатай холбоотой хэрэглэгч, харилцагчдын гомдол мэдээллийг 70071111 утсаар болон Харилцагчийн удирдлага, хамтын ажиллагааны албатай холбогдож шийдвэрлүүлдэг. Ёс зүйн зөрчил, аливаа зүй бус үйлдлийг талаарх мэдээллийг www.ari.mn веб сайт дахь "Шүгэл үлээх" цэсэнд хандаж, мэдэгдэж шийдвэрлүүлдэг. Бусад өргөдөл, гомдол мэдээллийг Бичиг хэргийн ажилтанд хандаж шийдвэрлүүлдэг |  |
| 13.1 Дотоодын худалдан авалт             | Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь            | АПУ ХК 70-75; АПУ Дэйри ХХК 67   |      | % | Нийт бэлтгэн нийлүүлэгчдийн (670 орчим бэлтгэн нийлүүлэгч) 70%-75% (500 орчим) нь дотоодын бэлтгэн нийлүүлэгч нар байдаг, АПУ Дэйри ХХК - үйлдвэрийн сэлбэг, үндсэн хөрөнгө( сандал ширээ TV, бусад)  |  |



|  |   |   |                                    |   |  |  |
|--|---|---|------------------------------------|---|--|--|
| 13. Тогтвортой өртгийн сүлжээний менежмент | 13.2 Тогтвортой, ногоон худалдан авалт            | Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь | АПУ ХК - 4;<br>АПУ Дэйри ХХК - 0.1 | % | <p>Нийт 24 бэлтгэн нийлүүлэгч нь (4%) ISO14000, Ecovadis Gold, FSC and Sedex зэрэг олон улсын стандарт хэрэгжүүлсэн. - ISO, Ecovadis Gold, FSC and Sedex зэрэг олон улсын стандарт хэрэгжүүлсэн 7 бэлтгэн нийлүүлэгч байна. Үүнд: LF Fulfilment Promocean, Celli Asia Pte LTD, Rastal GmbH&amp;Co.KG, RITZENHOFF CRISTAL AG, SAHM GmbH &amp; Co. KG, DTC World Corporation PTE LTD, IMBERA Mexico)</p> <p>- Байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхэлж буй: Дээрх олон улсын стандарт хэрэгжүүлсэн 7 бэлтгэн нийлүүлэгч бүгд байгальд ээлтэй үйл ажиллагаа эрхэлж байна. Үүнд: 100% recyclable glass үйлдвэрлэдэг, CO2 emission багасгахад 100% байгалийн хий болон ногоон эрчим хүчийг үйлдвэрлэлдээ ашигладаг, Eco-friendly материалаар үйлдвэрлэл явуулдаг (хуванцар болон бусад байгаль орчинд ээлтэй бус материалыг ашиглахгүй байх), биоцид болон аюултай бодисын хэрэглээг багасгахын тулд усыг озон болон хэт ягаан туяагаар цэвэршүүлэх технологи үйлдвэрлэлдээ ашигладаг, хог хаягдлаас зайлсхийж, эрчим хүч хэмнэх бодлого хэрэгжүүлдэг гэх мэт.</p> <p>- Дээрх олон улсын стандартуудыг хэрэгжүүлсэн 7 бэлтгэн нийлүүлэгч бүгд Heineken approved бэлтгэн нийлүүлэгч болно. АПУ Дэйри ХХК - Монт Яак брэндийн түүхий эдүүд нь органик түүхий эдийн шошготой түүхий эдийг сонгон худалдан авалт хийдэг</p> |  |
| 14. Авилгал болон ёс зүй                   | 14.1 Авилга, хээл хахуулийн эсрэг бодлого журам   | Авилгын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?  | Тийм                               |   | <a href="https://www.apu.mn/wp-content/uploads/2023/04/3-%D0%90%D0%B2%D0%BB%D0%B8%D0%B3%D1%8B%D0%BD-%D0%B1%D0%BE%D0%B4%D0%BB%D0%BE%D0%B3%D0%BE.pdf">https://www.apu.mn/wp-content/uploads/2023/04/3-%D0%90%D0%B2%D0%BB%D0%B8%D0%B3%D1%8B%D0%BD-%D0%B1%D0%BE%D0%B4%D0%BB%D0%BE%D0%B3%D0%BE.pdf</a>  |  |
| 15. Компанийн засаглал                     | 15.1 Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус байдал | Төлөөлөн удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь  | 33                                 | % | Компанийн тухай хуулийн 75.4-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүдийн 1/3-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх шаардлага хангасан   |  |
|  | 15.2 Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх        | Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?   | Тийм                               |   | <a href="https://www.apu.mn/investors-rules?lang=">https://www.apu.mn/investors-rules?lang=</a>  | Компанийн дүрэм болон Компанийн засаглалын дүрэм, журмуудаар хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалдаг. |
|  | 15.3 Компанийн засаглалын бодлого, журам          | Компанийн засаглалын бодлого, журам бий юу?   | Тийм                               |   | <a href="https://www.apu.mn/investors-rules?lang=">https://www.apu.mn/investors-rules?lang=</a>  | Компанийн засаглалын дүрэм, журмууд Компанийн вэбсайтад нийтэд ил байршдаг.                          |
|  | 16.1 Комплаенсын бодлого                          | Комплаенсын бодлого, журам бий юу?  | Тийм                               |   | <a href="https://www.apu.mn/wp-content/uploads/2024/01/23.19a_Compliance-guidelines_mon.pdf">https://www.apu.mn/wp-content/uploads/2024/01/23.19a_Compliance-guidelines_mon.pdf</a>  |  |

|                                    |   |   |      |   |  |   |
|------------------------------------|---|---|------|---|--|---|
| 16. Комплайнс                      | 16.2 Комплаенсын хөтөлбөр                   | Комплаенсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу? | Тийм |   | <a href="https://www.apu.mn/wp-content/uploads/2023/04/0_COBC_combined_mon.pdf">https://www.apu.mn/wp-content/uploads/2023/04/0_COBC_combined_mon.pdf</a>  | Бизнесийн ёс зүйн дүрмийн Шүгэл үлээх бодлого, Ашиг сонирхлын зөрчлийн бодлого. Мөнгө угаахтай тэмцэх болон хориг арга хэмжээний бодлогоор зохицуулдаг. |
| 17. Оролцогч талууд                | 17.1 Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/журам | Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?   | Тийм |   | <a href="https://apugroup-my.sharepoint.com/:w:/g/personal/tergel_d_apu_mn/EV7YfpFY07JjgeJNwuiRGvUBUNMOTB_XCNA1hRxMjqGyig?e=WdkwCH">https://apugroup-my.sharepoint.com/:w:/g/personal/tergel_d_apu_mn/EV7YfpFY07JjgeJNwuiRGvUBUNMOTB_XCNA1hRxMjqGyig?e=WdkwCH</a>  | "Харилцагч, хэрэглэгчийн санал гомдол шийдвэрлэх журам нь бүтээгдэхүүн үйл ажиллагаатай холбоотой харилцагч, хэрэглэгчийн гомдлыг шийдвэрлэхэд оршино.  |
|                                    | 17.2 Ажилчид/олон нийтийн санал гомдол      | Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдэрлэсэн хувь   | 100  | % |  |   |
|                                    | 17.3 Оролцогч талуудын оролцооны засаглал   | Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?   | Тийм |   | <a href="https://www.apu.mn/investors-rules?lang=">https://www.apu.mn/investors-rules?lang=</a>  |   |
| Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл | Устгалын /пестицид/ бодис                   | Устгалын бодис ашиглах бодлого журам бий юу?  | Үгүй |   |  |   |
|                                    | Тогтвортой газар, бэлчээр                   | MNS 6891:2020, Хариуцлагатай нүүдэлчин стандарт эсвэл түүнтэй ижил төстэй тогтвортой бэлчээрийн стандартыг хэрэгжүүлж чадсан бэлчээрийн талбайн хувь                | 0    | % |  |   |
|                                    | Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн       | Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь   | 0    | % | 2023 онд Хүнсний чанар, аюулгүй байдал алдагдсантай холбоотой татан авалт хийгдээгүй   |   |
| Боловсруулах                       | Химийн бодисын менежмент                    | Химийн бодис болон хортой материалыг зохистой хадгалах бодлого, журам   | Тийм |   | "Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль", "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам"-ыг мөрддөг. Химийн бодисын агуулах MNS 6458:2014 стандартын шаардлага хангасан МХГ-ын дүгнэлттэй. 2024 оны 1-р сард "Химийн хорт болон Аюултай бодисыг импортлох, ашиглах" тусгай зөвшөөрлийг БОАЖЯ-наас таван жилийн хугацаатай авсан |   |
|                                    | Дахин боловсруулсан материал                | Дахин боловсруулсан материал, орц ашиглалтын хувь   | 52   | % | Эргэлтээр ашиглах боломжтой лонхны нийт борлуулалтын тоо хэмжээг буцаан татан авсан эргэлтийн лонхны тоо хэмжээтэй харьцуулсан. /Нийт лонхны 48%-г дахин татан авч ашиглаж байна. Үүнд One-way bottle ороогүй/   |   |
|                                    | Ногоон шошго, гэрчилгээжүүлэлт              | Эко буюу ногоон шошго, гэрчилгээтэй бүтээгдэхүүний эзлэх хувь   | 6    | % | АПУ Дэйри ХХК-ийн нийт SKU буюу 67 төрлийн бүтээгдэхүүнүүдийн 4 нь Шилжилтийн үеийн органик баталгаажуулалтын гэрчилгээ авсан  |   |